

**МОНГОЛ УЛСЫН 2014 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ, ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2014 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2014 ОНЫ  
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛҮҮДИЙГ ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙСЭН ТАЛААР БАЙГАЛЬ  
ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 12 дугаар  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот


Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн нэгдүгээр хэлэлцүүлгийг 2014 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо дээрх хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг 2014 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хийлээ.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2014 оны төсвийн зарцуулалт”-ын “Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын багц”-ын “тодотгол 2”-ын “Мал хамгаалах сан 25,8 тэрбум төгрөг” гэснийг “38,8 тэрбум төгрөг” гэж өөрчлөх гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, хуулийн төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25.9.2-т заасны дагуу Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийсэн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт Төсвийн байнгын хороонд хүргүүлж байна.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Г.БАЯРСАЙХАН**

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
БАЙНГЫН ХОРОО ДЭМЖСЭН САНАЛ**

2014.12.16.

1.Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2014 оны төсвийн зарцуулалтын “Үйлдвэр хөдөө аж ахуйн сайдын багцын тодотгол 2-ын Мал хамгаалах сангийн 25.8 тэрбум төгрөг гэснийг 38.8 тэрбум төгрөг” гэж өөрчлөх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд**